

## МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

---

---

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

### Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Төв аймгийн Зуунмод сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Төв чандмань ДЭХГ” ОНӨААТҮГ (Ц.Батсүх)-т үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Б.Болор-Эрдэнэ)-нд даалгасугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 458 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

*Эрчим хүчний зохицуулах хорооны  
2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт*

## **ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1. Төв аймгийн Зуунмод сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м <sup>3</sup>	2,624.0
2	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	57,839.0
		Тогтмол	1,107.0
3	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м <sup>3</sup>	1,536.0
4	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	33,857.0
		Тогтмол	648.0
5	Төсөв, ҮААНБ-ын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/м <sup>3</sup>	3,840.0
		Төг/хүн	4,480.0
6	Орон сууцны халаалт (оюутны байр, подваль, "00"-ын ерөөний халаалт хамаарна)	Төг/м <sup>2</sup>	800.0
7	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/м <sup>3</sup>	1,300.0
		Төг/хүн	1,957.5